Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн
309 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Хууль тогтоомжийн нэр огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Биеийн тамир, спортын улсын хороо | Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга | Ахлах түшмэл, ТЗ-10 |

| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил |
|---|---|
| Ажлын өдөрт 8 цаг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бага тойруу-55, Спортын төв ордон |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Хууль тогтоомжийн хүрээнд Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төр, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна.

| |
|---|
| <u>Албан тушаалын зорилт:</u><br>1. Үндэсний шигшээ багийн спортын төрлийн холбоодтой гэрээ байгуулах, сургалт-дасгалжуулалтын төлөвлөгөөг батлуулах хамтран ажиллах, хяналт тавих;<br>2.Дасгалжуулагч, тамирчдын мэргэжил дээшлүүлэх, сургалтыг спортын эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа хариуцсан байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулах;<br>3.Тамирчдын бэлтгэл сургуулилтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах;<br>4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах. |

| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр**<br>*Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х* |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Журмын дагуу сонгогдсон спортын төрлийн холбоодтой гэрээ байгуулах; | Журмын дагуу сонгогдсон спортын төрлийн холбоотой гэрээ байгуулагдсан байна. | Х |
| | 2.Үндэсний шигшээ багийн сар, жил, улирлын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах, гэрээний дагуу хяналт тавих; | Батлагдсан төлөвлөгөөний дагуу гэрээний хэрэгжилт хангагдсан байна. | Х |
| | 3.Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Олимп, паралимпийн наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох үндэсний шигшээ багийн спортын төрлүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах. | Календарчилсан төлөвлөгөөний дагуу баг тус бүр арга хэмжээнд оролцсон байна. | Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Үндэсний шигшээ багийн тамирчдын сургалт, дасгалжуулалтыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, амжилтад тулгуурлан зохион байгуулахад заавар зөвлөмж өгөх, энэ чиглэлээр Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээ хариуцсан байгууллагатай нягт хамтран ажиллах; | Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвтэй хамтран дасгалжуулагч, тамирчдад орчин үеийн шинжлэх ухааны ололтод тулгуурлан гарын авлагыг бэлтгэн хүргүүлсэн байна. | Х |

МОНГОЛ УЛС ЗОВШООРОВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Спортын төрөл тус бүрийн спортын холбоод, Үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчдын эв нэгдэл, сахилга дэг журмыг бэхжүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах. | Үндэсний шигшээ багуудын тамирчин, дасгалжуулагчдын сахилга бат сайжирсан байна. | X |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Баг тамирчдын бэлтгэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй удирдан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | Дасгалжуулагч, тамирчдын бэлтгэл сургуулилтын чанарт хяналт тавин, шаардлагатай тохиолдолд сургалт дасгалжуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна. | X |
| | 2.Улс, олон улсын тэмцээнүүдэд үндэсний шигшээ багийн тамирчдын оролцож байгаа байдал, үзүүлж буй амжилтад судалгаа хийж дүгнэлт гаргах; | Тухай спортын төрөл өндөр хөгжсөн орны сургалт дасгалжуулалтын төлөвлөлтийг өөрийн орны орчин нөхцөлд тохируулан санал, дүгнэлтийг багуудад хүргүүлсэн байна. | X |
| | 3.Гадаад орнуудын шигшээ багийн сургалт дасгалжуулалтын туршлагаас судалж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах. | Спорт өндөр хөгжсөн орнуудын туршлагын өөрийн орны шигшээ багууд дээр хэрэгжүүлэн тухайн орны баг тамирчидтай хамтарсан бэлтгэл, сорилго тэмцээн зохион байгуулсан байна. | X |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны хуралд үндэсний шигшээ багтай холбоотой мэдээ, мэдээллийн цаг алдалдалгүй бэлтгэн хүргүүлэх; | Үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүд хүргэгдсэн байна. | X |
| | 2.Үндэсний шигшээ багуудтай холбоотой гарч буй захиргааны акт, хэм хэмжээний актын төслийг боловсруулах; | Хууль тогтоомжийн шаардлага хангасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, батлагдсан байна. | X |
| | 3.Үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой баримт | Архивын баримт бичгийн | |

МОНГОЛ УЛС ЗОВШООРОВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | бичгийг архивын нэгж болгон шилжүүлэх, хяналт тавих. | бүрдэл хангагдсан байна. | Х |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх. |
| **Мэргэжил** | | - спорт /1014/;<br>- багш, биеийн тамирын боловсрол /011410/;<br>- спортын менежмент. |
| **Мэргэшил** | | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. |
| **Туршлага** | | Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх. |
| **Ур чадвар** | **Удирдан зохион байгуулах** | - хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулах,<br>- гүйцэтгэлийг дүгнэж шаардлага тавьж чаддаг байх;<br>- удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах;<br>- албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх;<br>- бусад. |
| | **Дүн шинжилгээ хийх** | - спортын бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, зөвлөмж санал боловсруулах арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах; харьцуулалт хийх;<br>- мэдээллийг нэгтгэж дүгнэх, санал зөвлөмж боловсруулах;<br>- болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөх;<br>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | **Асуудал шийдвэрлэх** | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын |



МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| | | зөрчлөөс ангид шийдвэрлэх;<br>- хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>- бусад. |
| | **Манлайлах** | - ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах<br>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх<br>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах<br>- шинэ санаачилга, бүтээлч хандлагатай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- бусад. |
| | **Бусад** | - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;<br>- харилцааны соёлыг эрхэмлэх;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх;;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх;<br>- монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх. |

| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:<br><br>Биеийн тамир, спортын улсын хорооны дарга | |
| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>Ахлах мэргэжилтэн-1<br>Мэргэжилтэн-5<br><br>Нийт-6 | Бусад харилцах субъект:<br><br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;<br>- Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны гишүүд;<br>- Төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Иргэн хуулийн этгээд. |

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br><br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br><br>........... Г.Одбаатар .......<br>(Гарын үсэг) (Эцэг/Эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2020 оны 9 дугаар сарын 28-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 2020 09 09<br><br>Дугаар: 309 |
| **Албан тушаалын тодорхойлолт баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br><br>БИЕИЙН ТАМИР,СПОРТЫН УЛСЫН ХОРОО<br><br>Шийдвэрийн огноо: 2020.9.28<br><br>Дугаар: Б/08<br><br>(тамга/тэмдэг)<br><br>ДАРГА ........................ Ц.ШАРАВЖАМЦ<br><br>2020 оны 9 дугаар сарын 28-ний өдөр | |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ